



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/А

Төгөл

Цол тэмдэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сумын аварга малчин өрх шалгаруулах журам, сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арван дол дугаар жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх Усан туулай жилдээ "Мал аж ахуйн салбар"-т амжилт гаргасан Гун 6-р багийн малчин өрх Б.Амартүвшин, эхнэр Б.Туул нарт сумын аварга малчин цол тэмдэг олгосугай.

2. "Сумын аварга малчин өрх"-өөр шалгарсан малчдын шагналыг малчны хотонд гардуулж өгөх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын нягтлан бодогч (Т.Намжилсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР



D/Zahiramj

67 25000 17